



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 03 сарын 04 өдөр

Дугаар А/108

Арвайхээр

**Хөрөнгө зарцуулах тухай**


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.6, Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.10 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Батлан хамгаалахын сайд, аймгийн Засаг даргатай 2019 онд хамтран ажиллах гэрээний ажил үйлчилгээ 1.1, ажил үйлчилгээ 2.8 дахь заалтын дагуу “Монгол цэргийн өдөр”, Зэвсэгт хүчний 98 жилийн ойн баярыг тэмдэглэх, Батлан хамгаалах хууль тогтоомж, бодлого, үйл ажиллагааг иргэдэд сурталчилах, өсвөр үе, хүүхэд залуучуудад цэрэг-эх оронч үзэл хүмүүжлийг төлөвшүүлэх, Зэвсэгт хүчний анги салбарууд, Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын харилцаа хамтын ажиллагааг бэхжүүлэх арга хэмжээг зохион байгуулах ажилд шаардагдах төсвийг хавсралтаар баталсугай.

3. Ойн баярын арга хэмжээнд шаардагдах 2.899.000 (хоёр сая найман зуун ерэн есөн мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Ганболд)-д зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (И.Доржсүрэн)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100240

Аймгийн Засаг даргын 2019 оны 03 дугаар сарын 03 ны өдрийн захирамжийн хавсралт

“МОНГОЛ ЦЭРГИЙН ӨДӨР”, ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 98 ЖИЛИЙН ОЙН БАЯРЫГ ТЭМДЭГЛЭХ,  
БАТЛАН ХАМГААЛАХ БОДЛОГО, ЗОРИЛТ, ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ОРОН  
НУТАГТ СУРТАЛЧЛАХ АРГА ХЭМЖЭЭНД ШААРДАГДАХ ТӨСӨВ

№	Зохион байгуулах арга хэмжээ	Хамрагдах хүний тоо	Хугацаа	Шагнал урамшуулал	Нийт зардал (МЯН.ТӨГ)
1	Аймгийн Засаг даргын нэрэмжит Марш тактикийн аварга тасаг шалгаруулах тэмцээн	Цэргийн болон цэрэгжсэн байгууллагын бие бүрэлдэхүүн	03.12-13	1, 2, 3 дугаар байр болон тусгай байр - 500,000 Медаль -45x7000=315000 Өргөмжлөл-30000x4ш=120000 Цом-1ш 50,000	985,000
2	МСҮТ, ЕБС-ийн сурагчдын дунд цэрэгжилтийн спортын “Дөл” тоглолт	Аймгийн МСҮТ, ЕБС-ийн бүх сургуулиуд	03.12-13	1, 2, 3 дугаар байр 350,000 Медаль -45x3500=157500 Өргөмжлөл-4x20000=80000 Цом-30000	617,500
3	Аймгийн ЕБС-ийн сурагчдын дунд Эх орны сэдэвт Эссэ бичлэгийн уралдаан	ЕБС-ийн 10-12 дугаар ангийн сурагчид	03.04-14	1, 2, 3 дугаар байр - 180,000 Дурсамж-4x15000=60000	240,000
4	Үндэсний бөхийн барилдаан, гар бөмбөгийн тэмцээн	Цэргийн болон цэрэгжсэн байгууллагууд	03.14,15	Өргөмжлөл-6x20000=120000	120,000
5	“Эх орон танаа” Цэргийн дуу дуулаачдын аймгийн уралдаан	Иргэд, олон нийтийн дунд	03.10,11	LED дэлгэцийн түрээс	200,000
6	Баярын арга хэмжээг сурталчилах аннос хэвлүүлэх	Иргэд, олон нийтэд сурталчилах	03.04-18	21м2x6500=136500	136,500
7	“Арвайхээр цэргийн хүрээ”-ний нэгдсэн тоонд хэрэглэх баярын салот худалдан авах	Цэргийн болон цэрэгжсэн байгууллагууд, иргэд	03.16	6x25000=150000	150,000
8	Аймгийн төрийн цэргийн болон цэрэгжсэн байгууллагуудын удирдлага, “Бэлтгэл хурандаа” нарт хүндэтгэл үзүүлэх	20-22 хүн	03.18	Нэг хүнийг 20000 төгрөгөөр тооцов.	450,000
Бүгд					<b>2,899,000</b>